ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/,Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Барилга угсралтын ажлыг дулааны улиралд хийхээр тооцоологдсон байгаа тул БН ба Д-ийн зохих заалтыг баримтлан гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэсэн байна.

Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Архитектур төлөвлөлт: Уг барилга нь Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутаг дэвсгэрт барих **Спорт цогцолборын барилга** байна. Тэнхлэгээрээ 68.8м х 73.1м-ийн хэмжээтэй, хагас зоорьтой 2 давхар бөгөөд каркас бүтээцээр холбож төлөвлөсөн болно. Барилгын үндсэн бүтээц нь цутгамал төмөр бетон каркас ба 15 см-ийн зузаантай цутгамал хучилттай байна.

Цутгамал төмөр бетон каркасын ажил: Цутгамал төмөр бетон каркасыг хучилттай нь холбож арматурчлан нэгэн зэрэг давхар давхраар цутгана. Цутгамал төмөр бетон каркасын бетоны марк М300, бетоны анги 22.5 байх ба арматурын анги шинэ УСТ-аар SD 295 A, SD 295 B, SD 345, SR 235, SR 295 төрөлд хамаарна. Цутгамал төмөр бетон каркасыг модон хэв хашмалд цутгах ба хэв хашмалыг бетоны бат бэхийн 70%-ийг олсны дараа суллана. Цутгамал каркас цутгах ажлыг авторын хяналтын доор гүйцэтгэнэ.

Хучилтын ажил: Бүх давхрын хучилтыг харгалзах дам нуруу, цутгамал ханатай холбож арматурчлан цутгамалаар гүйцэтгэнэ. Цутгамал хучилтын зузаан бүх давхарт ижилхэн 15см байна. Хучилтын ажлын арматурын хамгаалах үе доод, дээд үед адилхан 15мм байх ёстой. Цутгамал хучилтын бетоны марк 300, бетоны анги В22.5 байх ба арматурын анги AIII, AII, AI ба шинэ УСТ-аар SD295 A, SD 295 B, SD 345, SR 235, SR 295 төрөлд хамаарна. Цутгамал хучилтыг модон хэв хашмалд цутгах ба хучилтын доороос хийх тулаасыг ойрхон 80см-ээс ихгүй алхамд байрлуулах хэрэгтэй. Үзэгчдийн суудлын шатлуурыг цутгамал хучилтан дээр мөн 300 маркийн буюу 22.5 ангийн бетоноор модон хэв хашмалд арматурчлаж цутгана. Цутгамал хучилтын бетоны бат бэхийн 90%-ийг олсны дараа хэв хашмалыг суллах хэрэгтэй. Цутгамал хучилтын ажлыг авторын хяналтын доор гүйцэтгэнэ. Суудлын доорхи шаталсан хучилтыг цутгамалаар мөн дээрхи хучилтын адил тоосгон өрөн хана дээр арматурчилж цутгана.

Ханын ажил: Гадна ханын дотор талд нь 38см-ийн зузаантай тоосгон хана өрж түүний гаднаас 15см-ийн зузаантай хөөсөнцөр дулаалга хийж гадна талд нь 3см-ийн шавардлага хийх ба дотор талд бассейны тусгаарласан хананд 25см-ийн тоосгон хана хэрэглэх ба хамар хананд 12см-ийн зузаантай тоосгон өрөг хийж гүйцэтгэх болно. Тоосгон хана, хамар ханын тоосгоны марк 100, цементэн зуурмагийн марк 50 байна. Гадна дотор ханыг өндрийн 60см дутамд байрлуулсан булангийн ба завсрын багануудад уулзах хэсэгт багананд байрлах 2ф8А- I анкеруудад бэхлэх замаар хийнэ. Харин дотор талын 24см, 12см-ийн зузаантай хамар ханын өндрийн 60 см дутамд 2ф8А – I арматураар тасралтгүй арматурчлан өөр хооронд нь холбоно.

Ялууны ажил: гадна хананд гарах цонхны нүхэн дээрхи ялууны үүргийг цутгамал дам нуруу гүйцэтгэнэ. Харин дотор хананд гарах хаалганы нүхэн дээр угсармал төмөр бетон ялуу угсарч тавина. Цутгамал каркасын багананд гадна дотор ханыг булан уулзварт холбохын тулд ханын өндрийн 60 см тутамд багананд байрлуулсан 2ф8А-I арматуран анкерт бэхэлнэ.

Бассейн болон спорт заалны дээврийн хучилт металл бүтээцийн ажил: Бассейны дээврийн хучилтанд нэг налуутай 24м-ийн алгасалтай металл дам нуруу МДН-1, спорт заалны хучилтанд хоёр налуутай 28м-ийн алгасалтай металл дам нуруу МДН-2-ыг тус бүр харгалзах төмөр бетон багануудын толгой дээр байрлуулсан бэхлэх анкер нарийвч М-1 дээр боож бэхэлсэн металл тулгуур МТ-1-ийн хацар дээр тус бүр 14 боолтоор боож бэхэлнэ. Мөн тэдгээрийн залгаасыг өөр хооронд боолтоор боож бэхэлнэ. Металл бүтээцийн гангийн ангилал С38/23, гангийн марк ОХУ-ынхаар ВСт3пс5 тус тус байна. Металл дам нуруунууд зурагт заасны дагуу өөр хоорондоо хэвтээ ба хөндлөн холбоосоор тасралтгүй холбогдоно. Металл дам нуруунууд дээр С төмөр тавьж бэхлэн түүн дээрээ дээврийн сэндвич хавтан бэхлэж гүйцэтгэнэ.

Гадна холбооны ажил: Баянхонгор аймгийн МХС ТӨК-иас олгосон техникийн нөхцөлд заасны дагуу ХШ-1 шүүгээнд 10х2 хосын блок суурилуулан ТПП 10х2 хосоор цэнэглэнэ. Тус 10х2 хосын кабелийг одоо байгаа 7, 8, 9-р худгуудаар дамжуулан татаж цааш барилга хүртэл шинээр газрын түвшнээс -1.0м гүнд 110мм-ийн диаметр бүхий полиэтиленэн 1 эгнээ яндантай сувагчлал болон шинээр төлөвлөх худгуудаар дамжуулан кабелиа татаж барилгад оролтыг хийнэ. Кабелийн худаг болон тавиур дамжиж буй кабель, төгсгөлийн төхөөрөмж бүрт кабелийн хос дугаарыг заасан бирк зүүж өгнө.

Цахилгаан хангамж: Цахилгаан хэрэглэгч нь цахилгаан хамгамжийн найдвартай ажиллагааны хувьд 2-р зэрэгт хамрагдана. Оролтонд зориулж стандартын шаардлагад нийцүүлж үйлдвэрлэсэн оролтын самбар /ОС-1, ОС-2/, ерөнхий /ЕС1, ЕС-2, ЕС-3, ЕС-4/ самбаруудыг цахилгааны өрөөнд байрлуулах ба цахилгаан эрчим хүчний хэрэглээг самбарт тавьсан тоолуураар тооцож гаргана. Барилгын гэрэлтүүлгийн тэжээлд гэрэлтүүлгийн самбар /ГС/, бусад хүчний тоног төхөөрөмжинд төхөөрөмжийн самбар /ТС/, гадна гэрэлтүүлэгт гадна гэрэлтүүлгийн самбар /ГГС/ самбаруудыг тус тус төлөвлөсөн.

Дотор гэрэлтүүлэгийн ажил: Гэрэлтүүлэгчдийг өрөөний зориулалт, архитектурын шийдэлд тулгуурлан сонгосон. Зоорийн давхарт байрлах техникийн өрөөнд ус чийгнээс хамгаалагдсан люминесцент чийдэнтэй гэрэлтүүлэгч, бусад хэсэг анги танхим, бэлтгэлийн өрөөнүүдэд люминесцент чийдэнтэй гэрэлтүүлэгч, гадна хаалганы дээр ус чийг тоосноос хамгаалсан улайсах чийдэнтэй гэрэлтүүлэгчдийг тус тус төлөвлөв.

Усан хангамжийн ажил: Дотор усан хангамжийн нэгдсэн систем сонгон авсан ба төвлөрсөн системээс хангагдана гэж төлөвлөв. Системийн усны найрлага MNS 9001:2005 ундны усны шаардлага хангасан байх шаардлагатай. Халуун хүйтэн усны түгээх болон босоо, салбар шугамыг ГОСТ 3262-91 маркийн ф15-65мм-ийн диаметртэй цайрдсан ган хоолойгоор салбар угсарна. Зоорийн давхарт галын түгээх болон босоо шугамыг 50мм зузаан пенополериутэн дулаалгаар дулааална. Шугам сүлжээнд задрах холбоос бүхий бөмбөлгөн хаалт тавина. Гол түгээх шугамыг 0.003 налуутайггаар узель руу угсрах ба таазанд бэхэлж өгнө.

Ариутгах татуурга: Бохир усыг өөрийн урсгалаар нь явуулж барилгын гадна байрлах үзлэгийн худагт холбохоор төлөвлөв. Бохир усны гаргалгааг гадна ариутгах татуургын зурагтай уялдуулж хийнэ. Бохир усны шугамыг PVC маркийн POLIPLAST фирмийн ф50-150мм-ийн диаметртэй хуванцар хоолойгоор хийхээр сонгосон ба шаардлагатай бол өөрийн орны стандартын шаардлага хангасан хуванцар хоолойг сонгон авч болно. Шугам сүлжээнд БНбД-ын дагуу шалгах таг, цэвэрлэгээний бөглөөг төлөвлөсөн. Бохир ус зайлуулах босоо шугамд шалгах таглааг шалнаас дээш 1,5метрт, агаар солилцуулах хоолойг барилгын дээврээс дээш 0,5 метрт гаргах шугам хоолойг зураг төсөлд заасан хэвгийтэйгээр угсарна.

Гадна дулааны ажил: Гадна дулаан хангамжийн холболтыг техникийн нөхцлийн дагуу одоо байгаа уурын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлж шинээр БЗИУ-100 маркийн тогоо тавьж, уурын зуухнаас ДХ-2 хүртэлх шугам сүлжээг өргөтгөн шинэчилж, дулааны худаг ДХ-2-ыг шинээр хийж барилгыг ф89х4.5 голчтой хоолойгоор холбоно. Хэрэглэгчийг хотын сүлжээнээс үл хамаарах схемээр холбон бие даасан дулаан хуваарилах төвтэй төлөвлөв. Шаардлагатай дулааны ачааллын хэмжээг барилгын халаалт, агаар сэлгэлтийн системийн ажлын зургийн өгөгдлийг үндэслэн тооцов. Дулааны сүлжээний дулаан зөөгч нь 95/70 температуртай халуун ус, халаалтын системийн дулаан зөөгч 90/70 температуртай халуун ус байна. Шугамын дулаалгыг 50мм зузаан пенополиуританаар хийнэ. Ф89мм голчтой хоолойн шулуун хэсэгт 3.5м, эргэлттэй хэсэгт 2м тутамд гулсах тулгуур хийнэ.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн **14.3-т "Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна", 14.6-т "энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна"** гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ. Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ИХБАЯР